



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 06 дугаар сарын 26

Дугаар 08/29

Баян-Өндөр сум

“Мэдээлэл шуурхай удирдлагын төв” УТҮГ-ыг
татан буулгах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл шуурхай удирдлагын төв” УТҮГ-ыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн татан буулгасугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Мэдээлэл шуурхай удирдлагын төв” УТҮГ байгуулах, дүрэм бүтэц, орон тоо батлах тухай” 74 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн “Орон нутгийн өмчит байгууллагуудын дүрэм, орон тоо, цалин хөлсний нийтлэг жишгийг шинэчлэн батлах тухай” 18/02 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ